


2018 оны 03 сарын 23-ны өдрийн
ТУЗ-ийн 02.00 тоот тогтоолын



Ag Re

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 2018

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК



АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	2
1. КОМПАНИЙН ТУХАЙ	
1.1. Компанийн танилцуулга, түүх	3
1.2. Компанийн зорилго, зорилтууд	3
1.3. Компанийн засаглалын тухай	4
2. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА	
2.1. Хөдөө аж ахуйн салбарын судалгаа	4
2.2. Даатгалын зах зээлийн ерөнхий төлөв байдал	6
3. БҮТЭЭГДЭХҮҮН	
3.1. Бүтээгдэхүүний судалгаа, танилцуулга	12
3.2. Бүтээгдэхүүний төлөвлөгөө	17
4. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
4.1. Даатгалын борлуулалтын сувгийн төлөвлөгөө	20
4.2. Маркетингийн төлөвлөгөө, иж бүрдлийн хөтөлбөр	21
5. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
5.1. Компанийн бүтэц, зохион байгуулалт	24
5.2. Менежментийн баг	25
6. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
6.1. Компанийн санхүүгийн төлөвлөгөөний танилцуулга	30
6.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан	31
6.3. Санхүүгийн байдлын тайлан	33
7. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	
7.1. Улс төр, эдийн засаг, эрсдэл	35
7.2. Хууль эрх зүйн орчны эрсдэл	38

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТ

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
МИД	Малын индексжүүлсэн даатгал
МИДТ	Малын индексжүүлсэн даатгал төсөл
МЭҮТ	Мал эмнэлэг үржлийн тасаг
ОУВС	Олон улсын валютын сан
ОУДД	Олон улсын давхар даатгал
ОТХН	Орлогод тооцсон хураамжийн нөөц
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЯ	Сангийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХАА	Хөдөө аж ахуй
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1. КОМПАНИЙН ТУХАЙ

1.1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ТҮҮХ

Монгол улсын Засгийн газар мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах шинэ тогтолцоог бий болгохоор 2005 оноос Дэлхийн банктай хамтран Малын индексжүүлсэн даатгал төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь малчин ард иргэдэд ашиг тусаа өгсөн үр өгөөжтэй ажил хэрэг болж, олны талархлыг хүлээсэн билээ.

Иймд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 5.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж, “Малын индексжүүлсэн даатгал” төслийг цаашид үргэлжлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2014 онд “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-ийг батлан гаргасан. Энэхүү хуулийг үндэслэн Засгийн газрын 280 дугаар тогтоолоор 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК зуун хувь төрийн өмчит хувьцаат компани болж байгуулагдлаа. Компани нь Монгол улсад хөдөө аж ахуйн давхар даатгалын тогтолцоог шинээр бий болгох зорилгоор ажиллаж байна.

Компанийн хувьцаа эзэмшигч нь Сангийн яам бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-т заасан “Малын индексжүүлсэн даатгал” (МИД), “Газар тариалангийн даатгал” болон бусад хэлбэрийн даатгалд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх юм.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь малын индексжүүлсэн даатгалын борлуулалтыг 2015, 2016, 2017 онуудад гурав дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд 2017 онд МИД-ын бүтээгдэхүүнд нийт 24,148 малчныг даатгалд хамруулж, 2 тэрбум 329 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 15,3 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 5,410 өрхөөр, даатгалын хураамжийн орлого 555 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. 2015-2017 онуудад олон улсын давхар даатгалын “SCOR”, “Swiss Re”, “Qatar Re”, “Hannover Re” зэрэг компаниудтай давхар даатгалын болон хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. 2017 онд МИД-ын бүтээгдэхүүний хүрээнд 9 тэрбум төгрөгийн эрсдэлийг даах чадавхтай болоод байна.

1.2 КОМПАНИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Алсын хараа:

Монгол улсын даатгалын тогтолцоог олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангахад оршино.

Эрхэм зорилго:

Монгол улсын хөдөө, аж ахуйн салбарыг бүхэлд нь хамарсан эрсдэлийг хамгийн бага түвшинд бууруулах замаар иргэдийн ажил эрхлэлтийг дэмжиж, хөдөө аж ахуй, санхүүгийн салбарын хөгжлийг шинэ шатанд авчрахад оршино.

Үндсэн зорилго:

Даатгагч, даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай давхар даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон, худалдах замаар оролцогч талуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөхөд оршино.

Зорилт:

- Малчдын амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Монгол улсын давхар даатгалын чиг хандлагыг тодорхойлогч компани байна.
- Дотоодын давхар даатгалын санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.
- Даатгалын зах зээлд тогтвортой оршин тогтнож, байгууллагын санхүүгийн тогтвортой өсөлтийг хангаж ажиллана.
- Олон улсын давхар даатгагчдын гүүр болж, олон улс дахь бизнесийн харилцаагаа өргөжүүлнэ.
- Үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөдөө аж ахуйн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.
- Даатгалын чадварлаг боловсон хүчин бэлтгэнэ.

1.3 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд Монгол улсын анхны давхар даатгалын компани бөгөөд цаашдаа үйл ажиллагааны цар хүрээгээ улам өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байгаагийн хувьд компанийн оновчтой засаглал нь зайлшгүй чухал юм. Иймд компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 онд шинэчлэн батлагдсан компанийн засаглалын кодексийг мөрдөн ажиллаж байгаа ба компанийн сайн засаглалыг хөгжүүлснээр хөрөнгө оруулалтын өгөөж, төслийн ашиг нэмэгдэж, хөрөнгийн зах зээлд орж ирэх урсгал идэвхжин, улмаар IPO хийх боломжууд улам бүр нэмэгдэх боломжтой юм.

Түүнчлэн компанийн сайн засаглалыг олон улсын жишигт нийцсэн түвшинд хүртэл хөгжүүлснээр байгууллагын бие даасан байдал бэхжиж, дотооддоо ТУЗ, хувьцаа эзэмшигч буюу Сангийн яам, гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, гадааддаа хөрөнгө оруулагчид, СЗХ, харилцагч даатгалын компаниуд, банк, хэрэглэгчид гэх мэт үйл ажиллагаанд оролцогч талуудад ил тод, хариуцлагатай, хүртээмжтэй, үр нөлөөтэй, шударга байх гэсэн засаглалын үндсэн зарчмууд хэрэгжиж, тогтвортой, урт хугацаанд ашигтай ажиллах, зах зээлд үнэ цэнээ олох, хамтын ажиллагааны байгууллага болон хэрэглэгчдэд итгэлцлийг бий болгох үндэс суурийг бий болгох юм.

2. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

2.1 ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН СУДАЛГАА

Мал аж ахуй

Улсын хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 66,2 сая толгой мал тоологдож хамгийн дээд хэмжээндээ хүрлээ. Үүнээс адуун сүрэг 3,9 сая, үхэр сүрэг 4,4 сая, хонин сүрэг 30,1 сая, ямаан сүрэг 27,3 сая, тэмээн сүрэг 0,4 сая толгой мал тоологдож, нийт малын тоо өнгөрсөн оныхоос 7,6 хувиар өссөн байна.

Том малын зүй бус хорогдол 2017 оны эхний 9 сард улсын хэмжээнд 622.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 641.0 (50.7%) мянгаар буурав. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзэхэд адуу 31.3 мянга, үхэр 66.5 мянга, тэмээ 0.5 мянга, хонь 278.4 мянга, ямаа 245.5 мянга байна. Нийт хорогдсон малын 44.7 хувийг хонь, 39.5 хувийг ямаа эзэлж байна. Улсын хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2017 оны эхний 9 сард 42.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.7 (7.9%) мянгаар буурав.

Улсын хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2017 оны эхний 9 сард 42.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.7 (7.9%) мянгаар буурав.

Хүснэгт 1. Мал төллөлт, зүй бусаар хорогдсон том мал, мянган толгой

Үзүүлэлт	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX
Мал төллөлт /хувь/	87.9	87.1	82.5	84.8
Бойжуулсан төлийн тоо /мян.толгой/	16898.9	18822.2	19175.7	22010.9
Зүй бусаар хорогдсон том мал /мян толгой/	300.8	431.8	1232.7	622.2
Адуу	17.7	22.5	32.7	31.3
Үхэр	27	27.1	121.1	66.5
Тэмээ	0.9	1	0.8	0.5
Хонь	115	173.3	463.2	278.4
Ямаа	140.2	207.9	624.5	245.5


Эх үүсвэр: ҮСХ

2017 оны жилийн эцсийн байдлаар малчин өрхийн тоо 169,7 мянга болж тоологдсон нь өнгөрсөн оныхоос 5,7 хувиар өссөн байна. Малтай өрхийн тоо 228,9 болж өнгөрсөн оныхоос 2,3 хувиар өссөн байна. Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэн үзвэл 200 хүртэл малтай өрх өмнөх оныхоос 1.8 пунктээр буурсан бол, 201-ээс дээш малтай өрх 0.04-1.0 пунктээр өсжээ. Эндээс харахад олон малтай өрхийн тоо нэмэгдэж байна.

Газар тариалан

Ургац хураалтын явцын мэдээгээр улсын хэмжээнд 2017 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар 166.1 мянган тонн үр тариа, 87.3 мянган тонн төмс, 63.1 мянган тонн хүнсний ногоо хурааж, 646.6 мянган тонн өвс хадлан, 15.6 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеэс үр тариа 126.0 (43.1%) мянган тонн, өвс хадлан 255.4 (28.3%) мянган тонн, хүнсний ногоо 6.6 (9.5%) мянган тонн, гар тэжээл 3.5 (18.2%) мянган тонн, дарш 0.4 (69.7%) мянган тонн, төмс 34.7(28.5%) мянган тонноор тус тус буурсан байна.

График 1. Хураасан ургац /мянган тонн/



Эх үүсвэр: ҮСХ

ХХААХҮЯ-ны мэдээгээр энэ оны 10 дугаар сарын 1-ний байдлаар улсын хэмжээнд 296.5 мянган га-д уринш боловсруулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 39.1 (11.6%) мянган га-гаар буурчээ.

Эрчимжүүлсэн мал аж ахуй

Уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-г эхлүүлэн хэрэгжүүлж байгаагаас махны болон сүүний чиглэлийн Суффолк, Беричон душер, Романов, Меринос зэрэг дэлхийн шилдэг дөрвөн үүлдрийн нийт 657 толгой хонийг Франц улсаас импортоор оруулж ирсэн.

Фермд байгаа сүүний чиглэлийн 61000 толгой үхрийн 25% 15250 толгой нь цэвэр үүлдрийн үнээ бөгөөд өдөрт дунджаар 1 үнээнээс 18 литр сүү, үлдсэн 75% буюу 45750 толгой нь эрлийз үнээ 1 үнээнээс 8 литр сүү дунджаар өгч байна. Жилдээ 41 сая литр сүү импортолдог, үүнийг дотооддоо үйлдвэрлэхийн тулд арвин ашиг шимтэй сүүний чиглэлийн 7000 орчим үхэр импортлон нутагшуулах шаардлагатай байна.

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд “Мах, мах-сүүний чиглэлийн үхрийн, махны чиглэлийн хонь, гахай, тахианы цогцолбор аж ахуйг шинээр байгуулах, өргөжүүлэх” төсөл сонгон шалгаруулж, махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж буй 14 аж ахуйн нэгжид 24.7 тэрбум төгрөгийн зээл олгосон.

Хүснэгт 2. Фермүүдийн тоо

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	1294	1662	1713	3395	3138	2739	2004
Сүүний үхрийн ферм	649	901	977	1332	1554	1172	1472
Махны үхрийн ферм	101	64	78	88	351	248	178
Мах, ноосны хонины ферм	128	200	229	1251	236	397	174
Сүүний чиглэлийн ямааны ферм	-	-	-	9	4	6	7
Гахайн ферм	190	187	181	314	476	331	Өрх-980 Ферм-70
Тахианы ферм	148	217	152	319	405	244	Өрх-1269 Ферм-40
Зөгийн ферм	68	81	89	64	299	161	Өрх-445 Ферм-60
Туулайн ферм	10	12	7	18	30	50	Өрх-445 Ферм-3

2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

Ерөнхий мэдээлэл

2017 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 40, даатгалын хохирол үнэлэгч 31 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 239 салбар, 11 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 209 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 50 салбар, 3 төлөөлөгчийн газар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 3. Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2013	2014	2015	2016	2017.III
1	Ердийн даатгалын компани	16	16	15	15	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани			1	1	1

4	Даатгалын төлөөлөгч	3187	3260	3340	3091	2893
5	Даатгалын зуучлагч	20	30	37	40	40
6	Даатгалын хохирол үнэлэгч	14	20	27	31	31
7	Актурч	15	15	15	15	21
8	Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани				42	42
9	Аудитор				126	126
	БҮГД	3253	3342	3436	3362	3170

Хүснэгт 4. Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо


№		2013	2014	2015	2016	2017.III
1	Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар	251	254	258	252	250
2	Даатгалын зуучлагч компанийн салбар	64	135	171	208	209
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар, төлөөлөгчийн газар	8	42	52	52	53
	БҮГД	323	431	481	513	512

Даатгаагчийн хөрөнгө

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 251.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44.3 тэрбум төгрөгөөр буюу 22.3 хувиар өссөн байна.

График 2

Давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгө, түүний өсөлт



Даатгалын компаниудын нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 80.0 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 17.0 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 3.0 хувийг тус тус эзэлж байна.

График 3

Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувь




Даатгаагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 13.4 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 24.0 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 7.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Сүүлийн 5 жилд даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн өсөх хандлагатай байгааг дараах дүрслэлээр харуулав.

График 4

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч /тэрбум төгрөг/




Даатгалын хураамж

Даатгалын компаниуд 2017 оны 3 дугаар улиралд 840,718 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 114.6 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 98.7 хувь буюу 112.0 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.9 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.3 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг давхар

даатгалын компани эзэлж байна. Тайлант улирлын даатгалын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 17.3 хувь өсөлттэй байна.

График 5

**Даатгалын нийт хураамжийн орлого, давхар даатгалын хураамж
/тэр бум төгрөг/**



Тайлант хугацааны даатгалын хураамжийн нийт орлогын 71.4 хувь нь даатгалын 4 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байгаагийн 26.7 хувийг хөрөнгийн даатгал, 21.5 хувийг ЖХАЖД, 12.0 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 11.2 хувийг гэнэтийн ослын даатгалын хураамж тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Даатгалын хураамжийн нийт орлого /хэлбэрээр/

№	Үзүүлэлт	Даатгалын нийт хураамжийн орлого		Өсөлт/бууралт
		2016.III	2017.III	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	9,270,250,368.1	12,852,234,571.8	38.6%
2	Хөрөнгийн даатгал	26,886,180,276.3	30,595,295,165.2	13.8%
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	11,352,789,381.9	13,751,019,667.2	21.1%
4	Ачааны даатгал	1,405,738,391.2	1,044,934,788.2	-25.7%
5	Барилга угсралтын даатгал	1,845,174,589.6	6,403,280,141.2	247.0%
6	Газар тариалангийн даатгал	13,699,146.0	91,265,567.3	566.2%
7	Мал амьтдын даатгал	669,887,663.3	3,124,408,738.4	366.4%
8	Агаарын хөлгийн даатгал	2,525,105,580.5	1,361,576,340.0	-46.1%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	313,084,263.7	372,675,220.7	19.0%
10	Хариуцлагын даатгал	5,018,596,515.5	7,877,789,937.2	57.0%
11	Санхүүгийн даатгал	2,682,534,614.5	2,094,438,108.1	-21.9%
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	22,354,498,179.1	24,576,615,745.7	9.9%
13	Зээлийн даатгал	637,125,413.6	1,994,253,294.4	213.0%
14	Итгэлцлийн даатгал	279,282,541.6	257,873,463.4	-7.7%
15	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	2,604,442,995.2	7,178,780,775.6	175.6%
16	Хугацаат амьдралын даатгал	115,149,295.6	165,602,030.1	43.8%
17	Хуримтлалын даатгал	60,561,681.0	69,451,816.0	14.7%


18	Тэтгэврийн даатгал	40,212,809.0	67,778,022.0	68.5%
19	Эрүүл мэндийн даатгал	712,934,620.4	692,800,386.9	-2.8%
Дүн		88,787,248,325.9	114,502,621,963.4	29.0%

Даатгалын нөхөн төлбөр

Даатгалын тохиолдлын улмаас 2017 оны 3 дугаар улиралд нийт 43,526 даатгуулагчдад 32.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 22,411 даатгуулагчид нийт 11.2 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 9,550 даатгуулагчид 6.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрүүд байна.

График 6

Даатгалын нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 22,411 даатгуулагчид нийт 11.2 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 9,550 даатгуулагчид 6.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрүүд байна.

Хүснэгт 7. Даатгалын хэлбэр тус бүрийн нөхөн төлбөр

№	Даатгалын хэлбэр	2016.09.30		2017.09.30	
		Нөхөн төлбөр	Нөхөн төлбөр авсан гэрээний тоо	Нөхөн төлбөр	Нөхөн төлбөр авсан гэрээний тоо
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2,411,038,581.9	6,921	3,380,731,159.1	8,144.00
2	Хөрөнгийн даатгал	1,883,420,420.2	2,572	5,884,547,921.6	2,044.00
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	5,550,496,311.4	10,331	6,046,138,609.2	9,550.00
4	Ачааны даатгал	175,396,008.8	31	1,957,388,405.6	48.00
5	Барилга угсралтын даатгал	19,542,580.0	1	449,544,855.9	1.00
6	Мал амьтдын даатгал	174,197,167.2	393	107,582,218.6	65.00
7	Агаарын хөлгийн даатгал	110,982,500.0	1		
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	13,139,118.0	256	30,721,165.4	84.00


9	Хариуцлагын даатгал	466,405,557.8	514	607,046,810.8	679.00
10	Санхүүгийн даатгал	1,564,700,457.2	483	1,413,727,948.7	399.00
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	10,652,333,950.5	24,518	11,199,700,952.7	22,411.00
12	Зээлийн даатгал	499,340,033.5	51	430,805,068.7	94.00
13	Итгэлцлийн даатгал	21,250,000.0	1		
14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	9,520,751.1	6	83,967,262.4	6.00
15	Хугацаат амьдралын даатгал	65,299,630.2	48	51,917,660.4	38.00
16	Хуримтлалын даатгал	72,915,242.0	47	40,510,968.0	11.00
17	Тэтгэврийн даатгал	11,459,119.9	12	16,967,798.0	0.00
18	Эрүүл мэндийн даатгал	468,095,884.4	1,561	709,211,261.0	1,417.00
	Дүн	24,169,533,314.4	47,747	32,410,510,066.4	44,991

: Тайлант хугацаанд нөхөн төлбөр гараагүй даатгалын хэлбэрүүдийг дээрх хүснэгтэд оруулаагүй болно.

Даатгалын нөөц сан

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 2017 оны 3 дугаар улиралд 62.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 27.0 хувиар өссөн байна. Сүүлийн 5 жилийн хугацааны даатгалын нөөц сангийн өсөлтийг дараах дүрслэлээр харуулав.

График 7



Даатгалын хохирлын харьцаа

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт хохирлын харьцаа 32.3 хувьтай байна. Үүнд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 37.5 хувьтай байна.

График 8



3. БҮТЭЭГДЭХҮҮН

3.1 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ СУДАЛГАА, ТАНИЛЦУУЛГА


Малын индексжүүлсэн даатгал

Зуд болон бусад гэнэтийн эрсдэлээс малчдын амьдралын баталгааг хамгаалах зорилгоор Монгол улсын Засгийн газар Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр МИДТ-ийг 10 жилийн турш амжилттай хэрэгжүүлжээ. МИД нь нэгж малчны малын хорогдлоор бус сумын хэмжээнд малын хорогдлын индекс гаргаж, даатгалын хохирол, нөхөн төлбөрийн хувь хэмжээг тооцоолдог онцлогтой. МИД нь Монгол улс төдийгүй дэлхийн мал аж ахуйд анх удаагаа хэрэгжиж байгаа даатгалын шинэлэг хэлбэр юм.

МИДТ нь 2005 оноос Баянхонгор, Увс, Хэнтий аймагт анхлан хэрэгжиж, 2010 оноос эхлэн жил бүр аймгийнхаа тоог нэмэх замаар 2012 оноос үндэсний хэмжээд хэрэгжиж эхэлсэн. 2015 оноос МИД-ын үйл ажиллагааг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК үргэлжлүүлэн авч гурав дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн гурав дахь жилийн борлуулалт, МИД-ын арван нэг дэх борлуулалтын улирал 2017 оны 2-р сарын 1-нд 21 аймгийн нийт 330 суманд эхэлснээс хойш 2017 оны 6-р сарын 30 хүртэлх хугацаанд оролцогч даатгагчид болох Ард, Бодь, Монгол, Монре, МИГ, Номин, Практикал, Тэнгэр, Хаан даатгалын компаниуд болон зуучлалаар Төрийн банк, Хаан банк оролцон нийт 24,148 малчинтай МИД-ын гэрээг байгуулж, 2 тэрбум 329 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 15,3 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 5,410 өрхөөр, даатгалын хураамжийн орлого 555 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

График 10. МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/



2017 оны борлуулалтаар нийт 2 тэрбум 329 сая төгрөгийн борлуулалт хийсний 2.39 хувийг “Ард даатгал” ХХК, 13.36 хувийг “Бодь даатгал” ХХК, 4.66 хувийг “МИГ даатгал” ХХК, 8.51 хувийг “Монгол даатгал” ХХК, 0.66 хувийг “Монре даатгал” ХХК, 0.44 хувийг “Номин даатгал” ХХК, 4.39 хувийг “Практикал даатгал” ХХК, 4.81 хувийг “Тэнгэр даатгал” ХХК, 0.75 хувийг “Хаан даатгал” ХХК, 32.49 хувийг “Төрийн банк”, 27.55 хувийг “Хаан банк” тус тус эзэлж байна.

График 11. МИД-ын хураамжийн орлого даатгалын компани, зуучлагч тус бүрээр





График 12. МИД-ын хураамжийн орлого даатгалын компани, зуучлагч тус бүрээр



Ингэснээр өнгөрсөн 11 жилийн хугацаанд давхардсан тоогоор 136,655 орчим малчин өрхийн 26,3 сая толгой малыг даатгалд хамруулж, 12,3 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ. Эдгээрээс 20,849 орчим малчин өрх нийт 3,7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг амьдрал дээр бодитойгоор мэдрээд байна. Тэрчлэн малчид даатгалд төлсөн хураамжийн хэмжээ, тухайн нутаг оронд гарсан эрсдэлийн хэмжээтэй уялдан харилцан адилгүй нөхөн төлбөрийг авч байна.

Газар тариалангийн даатгал

Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийн нэг болох “Газар тариалангийн даатгал”-ын хэлбэр нь Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын 80 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн үйлдвэрлэл давамгайлсан хөдөө аж ахуйтай манай орны хувьд дунд хугацаанд зах зээлийн багтаамж харьцангуй бага тул үндсэн “Малын индексжүүлсэн даатгал”-ын хажуугаар дэмжих чиглэлээр компанийн хураамжийн орлогын багцын диверсификаци хийх боломжтой байна.

Улаанбуудай тариалж буй талбайн хэмжээ нь бусад үр тариа, төмс, хүнсний ногоо зэргийн талбайн хэмжээтэй харьцуулахад харьцангуй том төдийгүй төмс, хүнсний ногооны талбайд усжуулалт харьцангуй их хийгддэг тул улаанбуудай шиг ган гачгийн эрсдэл их тохиолддоггүй байна. Жишээлбэл, 2015 оны намар Монгол улс нийт хурааж авахаар төлөвлөсөн улаан буудайн ургацынхаа 60-70 хувийг алдаж, хохирол хүлээсэн байна.

Мөн газар тариалангийн салбар бол хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай манай улсын хувьд ихээхэн эмзэг салбар тул энэ салбарт ажиллагсдын бизнес мөн адил ихээхэн эрсдэлтэй байдаг. Иймд тариалан эрхлэгчид өөрсдийн тариалангаа даатгуулах сонирхолтой байдаг хэдий ч арилжааны даатгалын компаниуд эрсдэлийг дангаар хариуцаж хүчрэхгүй тул эрэлтийг хангах нийлүүлэлт байхгүй байсаар байна.

“Үрийн тариалангийн даатгалын тухай” хуулийг 1999 онд баталсан. Хуульд улаанбуудайн үрийн тариаланг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах зорилгоор жил бүр заавал даатгаж байхаар тусгаж, хуульд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч өнөөг хүртэл хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм.

Энэ мэт бэрхшээлээс тариаланчид болон стратегийн бүтээгдэхүүн болох улаанбуудайг даатгалын аргаар хамгаалж, эрсдэл тулгарсан үед эдийн засгийн урьдчилсан хамгаалалтыг үзүүлэх шаардлагатай байгаа тул “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-аас улаанбуудайг даатгах ажлыг 2016 оноос туршилтын журмаар эхлүүлээд байна.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон хөдөө аж ахуйн эрсдэлийн менежментийн олон улсын шинжээч Олена Сосенкотой хамтран 2015 оны 10-р сараас 2016 оны 04-р сар хүртэл холбогдох судалгааг хийж, даатгалын бүтээгдэхүүний загварыг боловсруулсан. Даатгалын бүтээгдэхүүний судалгааг хийх явцад улаанбуудайг даатгалын бүтээгдэхүүнээр сонгосны дараа уламжлалт даатгал, индексжүүлсэн даатгалын төрлийн аль нэгийг нь сонгох хэрэгтэй болсон. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь малын хорогдлын индексэд суурилсан малын даатгалыг хэрэгжүүлж байгаа ба энэ тал дээр туршлагатай тул ургацын даатгалыг ижил төрлөөр явуулах саналтай байсан. Гэсэн хэдий ч олон улсын зөвлөх үндсэн эрсдэлийг авч үзэхгүй, талбайн ургацын бодит хохирлыг арай илүү ойролцоо байдлаар тооцдог уламжлалт даатгалын төрлийг ашиглаж үзэхийг зөвлөсөн. Олон улсын туршлагаас үзэхэд (Дэлхийн банкны олон удаагийн төслүүд) уламжлалт даатгал зарим шалтгааны улмаас тохиромжгүй байх тохиолдолд л индексжүүлсэн даатгалыг ашиглахыг зөвлөдөг байна.

Иймд эхлээд уламжлалт даатгалыг хэрэгжүүлээд туршилтын үр дүн хангалтгүй байвал индексжүүлсэн даатгал нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсэн. 2016, 2017 онуудад уламжлалт улаанбуудайн даатгалыг хэрэгжүүлсэн бөгөөд 2018 оноос индексжүүлсэн улаанбуудайн даатгалыг туршилтаар нэвтрүүлэхээр зорьж байна.

2016, 2017 онд хэрэгжүүлсэн Нэрлэсэн эрсдэлт улаанбуудайн даатгалын бүтээгдэхүүн

2016 онд туршилтын журмаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Цагааннуур, Түшиг, Хүдэр, Хушаат сумдууд болон Төв аймгийн Цээл сумдын тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд улаанбуудайн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгосон. 2016 онд туршилтын үр дүнд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын аж ахуйн нэгжийн 250 га газрыг Бодь даатгал ХХК даатгаж, 13 сая төгрөгийн даатгалын хураамжид төвлөрүүлж, 2,9 сая төгрөгийг давхар даатгалын хураамж болгон авсан. 2017 онд Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд үндэслэн ХХААХҮЯамны улаанбуудайн үр тариалах зөвшөөрөл авсан Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул, Хушаат сум, Төв аймгийн Жаргалант, Эрдэнэсант сум, Булган аймгийн Хутаг-Өндөр, Дархан-Уул аймгийн Хонгор сумын нийт 10 аж ахуйн нэгжийн 828 га талбайд андеррайтингийн үзлэг шалгалтыг хийж, нэрлэсэн эрсдэлт улаанбуудайн даатгалд Сэлэнгэ, Төв, Булган аймгийн нийт 8 сумын 9 аж ахуйн нэгжийн 817,07 га талбайд тариалсан үрийн болон таваарын улаанбуудайг хамруулж, нийт 46,3 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүллээ.

Туршилтын үр дүнгээс харахад даатгуулагч хангалтгүй хамрагдсан бөгөөд оролцогч талуудад дараах хүндрэл бэрхшээлүүд гарсан. Үүнд:

- Даатгалын компаниуд тариан талбай дээр очиж газар дээрх хяналт шалгалт хийх, хохирлыг үнэлэх зорилгоор 4-5 удаа очиж байгаа тул үйл ажиллагааны зардал маш өндөр байна.
- Хохирол үнэлгээг хийхэд цаг хугацаа, мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай байсан.
- Улаан буудайн даатгалын хувьд өндөр эрсдэлтэй, даатгалын хураамжийн хувь өндөр байгаа тул тариаланчдад даатгалын хураамжийг шууд төлөх бэлэн мөнгө байхгүй байна.
- Ихэнх тариаланчид банкны зээлтэй төдийгүй төрийн дэмжлэгийг харсаар байна.

Иймд 2018 онд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг илүү боловсронгуй, зардал багатай Индексжүүлсэн даатгалыг туршилтын журмаар нэвтрүүлэх
- Тариаланчдын даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэх
- Газар тариалангийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх /бие даасан хуультай болох/

2018 онд туршилтаар хэрэгжүүлэх газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүн

SCOR олон улсын давхар даатгалын компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж, тус компаниас индексжүүлсэн даатгалын талаар техникийн зөвлөмж, туслалцаа авч Монгол улсад тогтвортой хэрэгжих боломжтой газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг 2018 онд туршилтын журмаар хэрэгжүүлнэ.

Тус бүтээгдэхүүн нь хиймэл дагуул ашиглан цаг уурын статистик мэдээллийг гаргах бөгөөд улаанбуудайн агроном загварчлал ашиглан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах юм. Бүтээгдэхүүн хөгжүүлэх үйл явцыг харуулбал дараах байдалтай байна.

Зураг 1. Тариалангийн индексжүүлсэн даатгал бүтээгдэхүүн хөгжүүлэх үйл явц



2018 оны 4-5 дугаар саруудад индексжүүлсэн даатгалыг туршилтын аймаг сумдуудын тариаланчдад санал болгож, сонгогдсон даатгалын компаниуд борлуулалтыг туршилтаар хийнэ.

Хөрөнгийн даатгал /Хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал/

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 212 дугаар тогтоолоор Үндэсний хэмжээнд зохион байгуулагдах “Атрын-III аян”-ны “Газар тариалангийн техникийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн зориулалттай техникийг худалдан авахад зориулж Оросын Холбооны Улсын Эксим банкнаас 3-5 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр 10.0 сая ам.долларын зээлийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Оросын Холбооны Улсаас хөнгөлөлттэй зээлээр авч буй уг техник, тоног төхөөрөмжүүдийн Түрээслэгчээр Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм лизинг” ХХК, ХХААХҮЯ-ны “Тариалан эрхлэлтийг дэмжих сан” дамжуулан түрээслэгчээр ажиллаж байна.

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн хүнд машин механизм, тоног төхөөрөмжийг давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх талаар судалж байна. Цаашид тариалангийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн давхар даатгалын үйлчилгээ үзүүлэхээр зорьж байна.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /УИХ-ын 2003 оны 29 дүгээр тогтоол/, Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр /ЗГ-ын 2003 оны 160 дугаар тогтоол/, Монгол мал үндэсний хөтөлбөр /УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол/-ийн баримт бичигт мал аж ахуйн салбарын талаар 2010-2015 оныг хүртэл баримтлах чиглэл, хүрэх зорилтыг тодорхойлсон. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлэх хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулах мөн үйлдвэрийн аргаар боловсруулах махны хэмжээг жилд 100 мянган тонн, сүүг 200 мянган тоннд хүргэх зорилготой байна.

Хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо нэлээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байна.

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд “Мах, мах-сүүний чиглэлийн үхрийн, махны чиглэлийн хонь, гахай, тахианы цогцолбор аж ахуйг шинээр байгуулах, өргөжүүлэх” төсөл сонгон шалгаруулж, махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж буй 14 аж ахуйн нэгжид 24.7 тэрбум төгрөгийн зээл олгов.

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл /сая.төг/

2012	2013	2014	2015	2016	Нийт
3172.5	2170.1	3254.3	1909.0	709.0	11214.9

2016 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын А/103 тоот тушаалаар Сүүний чиглэлийн үхэр үржүүлж буй аж ахуйн нэгжүүдэд зээлийн дэмжлэг үзүүлэх төсөлд 20 аж ахуйн нэгжид 300 сая төгрөг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд таримал тэжээл тариалахад дэмжлэг үзүүлэх төсөлд 300 сая төгрөг, Гахайны аж ахуйн төсөлд 109 сая төгрөгийн дэмжлэгийг Мал хамгаалах сангаар дамжуулан 11214.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд олгосон.

Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн үхэр: Фермд байгаа сүүний чиглэлийн 61000 толгой үхрийн 25% буюу 15250 толгой нь цэвэр үүлдрийн үнээ бөгөөд өдөрт дунджаар 1 үнээнээс 18 литр сүү, үлдсэн 75% буюу 45750 толгой нь эрлийз үнээ 1 үнээнээс 8 литр сүү дунджаар өгч байна. Жилдээ 41 сая литр сүү импортолдог, үүнийг дотооддоо үйлдвэрлэхийн тулд арвин ашиг шимтэй сүүний чиглэлийн 7000 орчим үхэр импортлон нутагшуулах шаардлага байна.

Дээрх судалгаанд үндэслэн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн зүгээс 2018-2020 онуудад эрчимжсэн мал аж ахуйг давхар даатгах талаар судалж, үйлчилгээ үзүүлэх зорилттой ажиллаж байна.

3.2 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

МИД-ын борлуулалт, нөөц сангийн 2018 оны төлөвлөгөө

МИД-ын бүтээгдэхүүний борлуулалтыг 2018 онд борлуулалтыг 10 хувиар өсгөхөд МИД-ын хураамжийн орлого 2,56 тэрбум төгрөг, даатгалын компаниудын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө 1,15 тэрбум төгрөг болох төлөвтэй байна. Дунд түвшинд гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээг жил бүр хохирлын харьцааны 75 дахь персентайл (percentile) дээр таамагласан нь ойролцоогоор 1,2 тэрбум төгрөгийн хохирол учирч болзошгүй ба үүнийг хамтын эрсдэлийн сан, хамтын эрсдэлийн сангийн нөөц сан, дунд түвшний эрсдэлийн нөөц сангаас тус тус хааж, дунд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сангийн үлдэгдэл 2018 онд 2,6

тэрбум төгрөг болох төлөвтэй байна. Дээд түвшинд гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээг жил бүр хохирлын харьцааны 80 дахь персентайл (percentile) дээр таамагласан нь ойролцоогоор 121,5 сая төгрөгийн хохирол учирч болзошгүй ба үүнийг дээд түвшний эрсдэлийн нөөц сангаас хааж, дээд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сангийн үлдэгдэл 2018 онд 788,6 сая төгрөг болох төлөвтэй байна.

Хүснэгт 8. МИД-ын бүтээгдэхүүний борлуулалтын 2018 оны төлөвлөгөө

МИД	2018 /төгрөг/
Нийт даатгалын үнэлгээ	60,730,202,597.49
Нийт хураамж	2,562,026,459.08
2017 оны ОТХН-ийн үлдэгдэл	460,217,295.80
ОТХН-ийн өөрчлөлт	845,468,731.50
Орлогд тооцсон хураамж	800,624,837.59
2018 оны ОТХН-ийн үлдэгдэл	505,061,189.71

Дунд түвшний эрсдэлийн нөөц сан

ХААДД-ын хариуцлага	1,665,317,198.40
ОУДД-ын хариуцлага	3,202,533,073.85
ОУДД-ын хариуцлагын дээд хэмжээ	4,867,850,272.25
Учирч болзошгүй хохирол (VaR at 95%)	3,535,596,513.53
Учирч болзошгүй хохирол (VaR at 85%)	2,562,026,459.08
Учирч болзошгүй хохирол (VaR at 75%)	1,255,392,964.95
Хамтын эрсдэлийн сан	1,152,911,906.59
Хамтын эрсдэлийн сангийн нөөц сан	20,863,096.08
ОУДД-ын хураамж (Дунд түвшинд)	461,164,762.63
Давхар даатгалын зардал	185,676,840.97
2017 оны ДТЭ-ийн нөөц сангийн үлдэгдэл	2,476,946,148.78
2018 оны ДТЭ-ийн нөөц	128,101,322.95
2018 оны ДТЭ-ийн нөөц сангийн үлдэгдэл	2,605,047,471.73
Эрсдэл даах чадамж	6,981,355,548.25

Дээд түвшний эрсдэлийн нөөц сан

ХААДД-ын хариуцлага	182,190,607.79
ОУДД-ын хариуцлага	1,803,687,017.15
ОУДД-ын хариуцлагын дээд хэмжээ	1,985,877,624.94
Учирч болзошгүй хохирол (VaR at 95%)	1,105,289,687.27
Учирч болзошгүй хохирол (VaR at 90%)	449,403,499.22
Учирч болзошгүй хохирол (VaR at 80%)	121,460,405.19
Засгийн газраас төсөвлөгдсөн хураамж	429,969,834.39
ОУДД-ын хураамж (Дээд түвшинд)	211,948,407.07

Давхар даатгалын зардал

2017 оны ДТЭ-ийн нөөц сангийн үлдэгдэл	697,562,453.67
2018 оны ДТЭ-ийн нөөц	91,095,303.90
2018 оны ДТЭ-ийн нөөц сангийн үлдэгдэл	788,657,757.56

Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний 2018 оны төлөвлөгөө

2018 онд үрийн тариалангийн даатгалын 1125 га талбайг даатгалд хамруулж, даатгуулагчаас авах даатгалын нийт хураамжийн орлогыг 48,6 сая төгрөг байхаар төлөвлөж байна. Үүнээс Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн цэвэр хураамж 12,3 сая төгрөг болохоор байна.

Нэрлэсэн эрсдэлт улаанбуудайн даатгалын бүтээгдэхүүн	2018 /төгрөг/
Даатгалын үнэлгээ	1,033,886,581.14
Нийт хураамж	48,644,084.24
ХААДД-ын давхар даатгалын хураамж	47,184,761.72
Комиссын зардал	4,718,476.17
ОУДД-ын давхар даатгалын хураамж	38,915,267.40
Комиссын зардал	8,755,935.16
ХААДД-д үлдэх хураамжийн дүн	12,306,953.31
Газар тариалангийн даатгалын нөөц	13,133,902.75

4. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөнд тодорхойлогдсон алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудын хүрээнд дотоод боломж, санхүүгийн төлөвлөгөөт тооцооны ашигтай хувилбарыг үндэслэн Монголдоо анхны “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ын хувьд зах зээлийг хошуучлагч нь байж, зах зээлийн лидерийн стратегийг баримтлан, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах ба шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, чанараа сайжруулах стратегитай хослуулахаар ажиллаж байна. Нийтийн арилжааны болон холимог даатгалын эрэлт хэрэгцээний дагуу бүтээгдэхүүнээ бэлтгэж, бүхэлдээ эрэлт нийлүүлэлтийн зохистой тэнцлийг хангахад чиглэгдсэн бодлого боловсруулж баримтална.

Үйлчлүүлэгчийн төлөв байдлын тухайд өнгөрсөн хугацаанд МИДТ-ийн хүрээнд 2006 оноос хойш одоог хүртэл МИД болон даатгалын ач холбогдлын талаар хөдөө орон нутгийн удирдлагууд, ард иргэд, малчдад сургалт сурталчилгааг хийж ирсэн. Төслийн хүрээнд нүүр тулсан сургалтыг жил бүр зохион байгуулж, малын даатгал болон бусад даатгалын ач тус, өгөөжийн талаар ухуулга сургалт хийсэн. Тиймээс МИД-ын бүтээгдэхүүний талаар тодорхой мэдлэгтэй болсон бөгөөд цаашид хөдөө аж ахуйн даатгалын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлж үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангаж ажиллана.


Өрсөлдөөний тухайд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь дотоодын давхар даатгалын зах зээл дээр олон улсын давхар даатгалын компаниудтай өрсөлдөж цаашид бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, зах зээлээ өргөжүүлэх, олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлж, өмнөө тавьсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж ажиллана.

4.1. ДААТГАЛЫН БОРЛУУЛАЛТЫН СУВГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


МИД-ыг хөдөө орон нутагт борлуулахад учирдаг гол хүндрэл нь тархан суусан малчдад хүрч очих зардал өндөртэй байдаг тул үйл ажиллагааны зардал өсгөж ингэснээр даатгуулагч малчнаас авах хураамжийн хэмжээг өндөр болгодог. Иймд цаашид МИД-ын урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхэд үйл ажиллагаа болон зардал багатай борлуулалтын сувгаар дамжуулан малчдад МИД-ын бүтээгдэхүүнийг хүргэх шаардлага байгаа юм. Энэ талаар “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн зүгээс хөдөө орон нутагт хамгийн олон салбар бүхий Хаан банк болон Төрийн банктай 2016 оноос МИД-ын зуучлалын гэрээ байгуулан амжилттай хамтран ажиллаж байгаа бөгөөд цаашид улам бүр борлуулалтыг нэмэгдүүлэн малчид даатгуулагчдын хэрэгцээг ханган ажиллаж байна. Мөн 2018 онд МИД-ын хураамжийн хувийг 21 аймаг 331 сумаар шинэчлэн тогтоосон бөгөөд хураамжийн хувь 12 хувиар буурч байгаа тул малчдын хамрагдалт нэмэгдэх төлөвтэй гэж үзэж байна.

Мөн түүнчлэн хөдөө орон нутагт малчидтай жилийн 4 улиралд хамтран ажилладаг мал эмнэлгийн үйлчилгээг ашиглан МИД-ын борлуулалт хийх суваг болон мал эмнэлэг, сум орон нутгийн холбогдох албан тушаалтнууд, багын засаг дарга нараар дамжуулан даатгалын ач холбогдлын талаар мэдээлэл түгээн ажиллана.

Схем 1. Борлуулалтын үйл ажиллагааг хянах схем



Схем 2. Тайлан, мэдээний үйл ажиллагаа



Мөн ХХААХҮЯ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан хөдөө орон нутагт малын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Улс, аймаг, сумын сайн малчин болон Мянгат малчин МИД-д даатгагдсан байх гэдэг тодорхойлолтыг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-аас авдаг байх зохицуулалтыг хийж ажиллана.

4.2. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ИЖ БҮРДЛИЙН ХӨТӨЛБӨР

Маркетингийн төлөвлөгөөний зорилго:

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг зорилтот зах зээлд таниулах, хүргэх замаар компанийн борлуулалтын орлогын тогтвортой өсөлтийг хангахад маркетингийн стратеги төлөвлөгөөний зорилго оршино.

Маркетингийн төлөвлөгөөний зорилт:

- Малчдын амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалах МИД-ын хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- Компанийн зүгээс газар тариалан эрхлэгчдэд санал болгож буй шинэ бүтээгдэхүүнийг сурталчлан таниулж, бүтээгдэхүүний борлуулалтын төлөвлөгөөний биелэлт, тогтвортой өсөлтийг хангах.
- Оновчтой маркетингийн сувгийг ашиглан алслагдсан бүс нутаг, сумдын малчид, тариаланчдад мэдээллийг жигд тархаах, бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн маркетингийн төлөвлөгөөг хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн нөхцөл байдал, мал аж ахуй болон газар тариалангийн судалгаа, шинжилгээнд тулгуурлаж, богино болон урт хугацааны үр дагаврыг тооцсон байдлаар нэгтгэн ашиглана.

Маркетингийн төлөвлөгөөний хүрээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон оролцогч талууд болох даатгалын компаниуд, түүний төлөөлөгч, зуучлагч нар, аймаг сумдын удирдлага, малчид, тариаланчдыг оролцуулан маркетингийн зорилго зорилтуудыг хэрэгжүүлэх боломж, нөөц, гарч болох нөхцөл байдал, арга замуудыг тодорхойлно.

Маркетингийн иж бүрдлийн хөтөлбөр:

МИД-ын бүтээгдэхүүний хүрээнд:

- Сурталчилгаа
 - МИД-ын босго үзүүлэлт болон малын тоо өөрчлөгдөж байгаатай холбогдуулан гарын авлагыг шинэчлэн хэвлүүлэх
 - Даатгуулсан малчдад тараах цаг тооны бичиг эсвэл календарь хэвлүүлэх
 - Орон нутгийн төлөөлөгчөөр дамжуулан малчдад тараах сонин, брошур хэвлүүлэх
 - Олон нийтийн хэрэгсэл, телевиз радиогоор нэвтрүүлэг бэлтгэн цацах
 - Жил бүр зохион байгуулагддаг улсын малчдын зөвлөгөөнд оролцох /судалгаа авах, мэдээлэл хүргэх, брошур тараах/
 - “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн танилцуулга бүхий тайланг хэвлэн орон нутаг, сумдын засаг дарга, мэргэжилтнүүдэд тараах
 - Сангийн яам болон ХХААХҮЯ-аас зохион байгуулж буй өдөрлөгт оролцон МИД-ын талаар танилцуулах
 - МИД-ын борлуулалт явагдаж буй үед хөдөө орон нутгийн мэргэжилтэн, төлөөлөгч нарын идэвхжүүлэх үүднээс шагнал урамшууллын уралдаан зарлах
- Сургалт
 - МИД-ын борлуулалт явагдаж буй үед хөдөө орон нутгийн мэргэжилтэн, малчдад газар дээр нь сургалт хийх, мэдээлэл солилцох, танилцуулга тараах
 - МИД-д Төрийн банк болон Хаан банктай зуучлалын гэрээ байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан хөдөө орон нутагт дахь салбарын ажилтнуудад МИД-ын борлуулалт болон хаалтын талаар сургалт хийх

Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний хүрээнд:

- Сурталчилгаа
 - Тариалангийн даатгалын талаар энгийн үг хэллэгтэй товч тодорхой мэдээлэлтэй брошур гаргаж, олон нийтэд тараах
 - Жил бүр гардаг тариалангийн салбарын талаарх мэдээллийг багтаасан сэтгүүлд тариалангийн даатгалын талаар мэдээлэл бэлдэж, гаргах
 - Газар тариалангийн нэвтрүүлэг бэлтгэн цацах /улаанбуудайн даатгалын танилцуулга, нөхөн төлбөрийн мэдээлэлтэй/
 - Жил бүр зохиогддог улсын тариаланчдын зөвлөгөөнд оролцох /судалгаа авах, мэдээлэл хүргэх, брошур тараах /
 - Сангийн яам болон ХХААХҮЯ-аас зохион байгуулж буй өдөрлөгт оролцон улаанбуудайн даатгалын талаар танилцуулах
- Сургалт, судалгаа, хэлэлцүүлэг
 - Тариалангийн индексжүүлсэн даатгалын хүрээнд тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд, тариалангийн холбоонуудад сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох судалгааг авах
 - Тариалангийн индексжүүлсэн даатгал, талбайн газар дээрх үзлэг шалгалт андеррайтинг болон даатгалын загварчлалын талаар оролцогч даатгалын компаниудад сургалт зохион байгуулж, чадавхжуулах
 - Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах болон сурталчлан таниулах зорилгоор Тариаланчдын холбоо, холбогдох яамнууд, тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, даатгалын компаниудын дунд хэлэлцүүлэг хийж, судалгаа авах
- Борлуулалтын урамшуулал:
 - Шилдэг даатгалын төлөөлөгч сонгон шалгаруулж мөнгөн урамшууллаар шагнах
- Биечилсэн худалдаа:


- Биечилсэн худалдаа хийж байгаа даатгалын төлөөлөгчид, зуучлагч банкны теллерүүдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, шууд борлуулалтыг нэмэгдүүлэх.
- Олон нийтийн харилцаа:
 - Аймаг, сум, багийн хэмжээнд зохион байгуулагддаг Засаг дарга нарын уулзалт малчид, тариаланчдын хурал зөвлөгөөнүүдэд орон нутгаас нь болон компанийн зүгээс оролцож, компанийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах, хэрхэн даатгуулах талаар зөвлөгөө өгөхөөс гадна даатгалын компани, төлөөлөгч, зуучлагч нартай холбох
 - Аймгийн хэмжээнд малчид тариаланчдад зориулсан томоохон арга хэмжээг тааруулан даатгалын өдөрлөг зохион байгуулах
 - Газар тариалангийн даатгалын талаар холбогдох албан тушаалтнууд болон тариаланч нартай уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж сурталчлан таниулах
- Шууд маркетинг:
 - Мессеж илгээх:
Мобиком, Юнитель, Скайтел, Жи-мобайлын сүлжээний малчин, тариаланч нарын үүрэн утас руу илгээх

5. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Экспортын даатгалын газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, Санхүү, удирдлагын газар гэсэн 5 газар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.

Схем 3. Байгууллагын бүтэц



5.2. МЕНЕЖМЕНТИЙН БАГ

Андеррайтингийн газар:

Андеррайтингийн газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, давхар даатгалын гэрээ байгуулан, даатгагч нарын давхар даатгуулах эрсдэлийн үнэлгээг /андеррайтинг/ хийх;
2. МИД-ын бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ, давхар даатгалын хураамж болон оролцогчийн хураамжийн тооцооллыг хийх;
3. Орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй харилцаж ажиллах;
4. Давхар даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой актуар тооцооллыг хийх;
5. МИД болон бусад давхар даатгалын бүтээгдэхүүний бүртгэл, эрсдэл тооцооллын програм хангамжийг боловсруулах;
6. Ажилтнуудын компьютерт зайлшгүй шаардлагатай болон хэрэгцээтэй бүртгэлийн, системийн болон хэрэглээний программ хангамжийг суулгаж өгөх, компанийн цахим хуудасны мэдээллийг сүлжээнд оруулж, олон нийтэд хүргэх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, засвар үйлчилгээг хийх;
7. Оролцогч даатгалын компаниуд болон зуучлагч банкнуудтай хамтарч ажиллах;

Андеррайтингийн газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.
- Андеррайтер 1: МИД-ын бүтээгдэхүүн хариуцан ажиллах бөгөөд хөтөлбөрт оролцогч даатгалын компаниудтай харилцаж ажиллана. Дундын дансыг бүрдүүлэх, зохион байгуулах болон давхар даатгалын хураамж төвлөрүүлэх, эрсдэлийн тооцооллыг хийж гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн МИД-тай холбоотой тооцоолол болон дансны гүйлгээг хянаж ажиллана.
- Андеррайтер 2: Газар тариалангийн даатгал хариуцсан ажилтан. Хөтөлбөрт оролцогч компаниудтай газар тариалангийн бүтээгдэхүүнийг хариуцан ажиллаж, давхар даатгуулах эрсдэлийн үнэлгээ хийнэ.
- Актуарч: Шинэ болон хэрэгжүүлж буй даатгалын бүтээгдэхүүний хураамж тооцоолол, хохирол үнэлгээний актуар тооцооллыг хийнэ.
- Даатгалын шинжээч 1: Хөдөө аж ахуйн давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа, шинжилгээ хийж, мэдээлэл боловсруулна. Орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй харилцаж ажиллана. Аймаг сумдын удирдлагууд болон холбогдох ажилтнуудтай хамтран ажиллаж, компанийн үйл ажиллагааг хөдөө орон нутагт тогтвортой хэрэгжүүлнэ.
- Даатгалын шинжээч 2: Давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа, шинжилгээг хийж, мэдээлэл боловсруулна. Орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй харилцаж ажиллана.
- Мэдээлэл технологийн ажилтан 1: МИД-ын болон бусад давхар даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх, эрсдэл тооцоог хийх програм хангамжийн асуудлыг хариуцан ажиллана.
- Мэдээлэл технологийн ажилтан 2: Компанийн системийн зохицуулагчийн үүргийг хүлээж бүх компьютер, тоног төхөөрөмж, дотоод болон гадаад сүлжээг хэвийн ажиллагаатай байлгана. Компанийн цахим хуудасны мэдээллийг сүлжээнд оруулна.
- Агрономич: Компанийн газар тариалангийн даатгалтай холбоотой асуудлыг хариуцан ажиллана. Газар тариалангийн даатгалын андеррайтинг, хохирол үнэлгээг хийх, холбогдох зааврыг боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлж, тариалангийн сургалт хийнэ.

Бизнес хөгжил, төслийн газар:

Бизнес хөгжил, төслийн газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Даатгалын шинэ бүтээгдэхүүний загварыг гаргах;

2. Тариалангийн даатгалыг хэрэгжүүлэх;
3. Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлыг хийж хэрэгжүүлэх;
4. Туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах, давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа шинжилгээ хийж, мэдээлэл боловсруулах;
5. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тооцоолол хийх, батлуулах, зарцуулалтад хяналт тавих;
6. Олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх;
7. Компанийн сургалт сурталчилгаа, гадаад харилцаа болон хамтын ажиллагааг бэхжүүлэх;
8. Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах;

Бизнес хөгжил, төслийн газар дараах орон тоотой байна.Үүнд:

- Газрын дарга.
- Шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан: Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, турших судалгааны ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Төслийн менежер: Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, төслийн танилцуулга, бичиг баримт боловсруулах, гүйцэтгэл, нөхцөл байдалд шинжилгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хөрөнгө оруулалтын шинжилгээ хийнэ.
- Эрсдэлийн шинжээч 1: Компанийн үйл ажиллагааны эрсдэл, даатгалын гэрээний эрсдэл, давхар даатгалын эрсдэл, санхүүгийн, хүний хүчин зүйлийн, улс төрийн хууль эрх зүйн, зах зээлийн эрсдэлийн шинжилгээ хийнэ.
- Эрсдэлийн шинжээч 2: Компанийн үйл ажиллагааны эрсдэл, даатгалын гэрээний эрсдэл, давхар даатгалын эрсдэл, санхүүгийн, хүний хүчин зүйлийн, хууль эрх зүйн, улс төрийн, зах зээлийн гэх мэт эрсдэлийн шинжилгээ хийнэ.
- Эрсдэлийн шинжээч 3: Компанийн үйл ажиллагааны эрсдэл, даатгалын гэрээний эрсдэл, давхар даатгалын эрсдэл, санхүүгийн, хүний хүчин зүйлийн, хууль эрх зүйн, улс төрийн, зах зээлийн гэх мэт эрсдэлийн шинжилгээ хийнэ.
- Гадаад хамтын ажиллагааны ажилтан: Олон улсын болон төр,хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Компанийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
- Маркетингийн менежер: Компанийг болон давхар даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулах, холбогдох сургалт семинар зохион байгуулах зэрэг ажлыг зохион явуулна.

Экспортын даатгалын газар:

Экспортын даатгалын газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Экспортын даатгалын зах зээл дэх жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд буюу даатгуулагчдад чиглэсэн дэлгэрэнгүй судалгааг боловсруулах;
2. Экспортын зах зээлд тулгарч буй үндсэн эрсдэлүүдэд дэлгэрэнгүй шинжилгээ хийх;
3. Даатгуулагчдын шаардлага, хэрэгцээнд нийцсэн экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах;
4. Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд шаардлагатай андеррайтингийн журам, эрсдэлийн удирдлагын зарчим, үнэлгээний аргачлал, актуар тооцоолол, нөхөн төлбөрийг олгох явц, даатгалын өргөдлийн маягт, загварууд, даатгалтай холбоотой бусад баримт бичгийг боловсруулах;
5. Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэх үүднээс олон улсын нэр хүнд бүхий байгууллага, зөвлөх, мэргэжилтний сургалтад хамрагдаж туршлага, ур чадвар эзэмших;
6. Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

Экспортын даатгалын газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.
- Зохицуулагч мэргэжилтэн: Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажлын үр дүнг хариуцах, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг дүрэм, журамд заасан зарчмын дагуу хэрэгжүүлэн ажиллана.

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар:

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Компанийн дүрмийн сангийн хөрөнгийг холбогдох зохицуулалтын хүрээнд удирдах;
2. Эрсдэлийн сангууд болох алдагдлаас хамгаалах сан, хамтын эрсдэлийн сан, дээд болон дунд түвшний эрсдэлийн сангуудыг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах;
3. Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг бүрдүүлэх, шийдвэрлэх;
4. Нөхөн төлбөрийн тооцоолол хийх, даатгуулагчдад нөхөн төлбөр олгох асуудлыг хариуцах;
5. Хөрөнгө оруулалтын сувгийн судалгаа хийх;

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.
- Хөрөнгө оруулалтын шинжээч: Компанийн нөөц сангууд болох алдагдлаас хамгаалах сан, дээд болон дунд түвшний эрсдэлийн сангуудын зохион байгуулалтыг хийнэ.
- Нөхөн төлбөрийн менежер: Давхар даатгалын гэрээний хүрээнд гарсан нөхөн төлбөрийн тооцооллыг хийх, давхар даатгуулагчид олгох ажлыг хариуцна. Хамтын эрсдэлийн сангийн зохион байгуулалтыг хийнэ.
- Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажилтан: Хөрөнгө оруулалт хийх сувгуудыг судлан компанийн хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлнэ. Компанийн дүрмийн сангийн зохион байгуулалтыг хийнэ.

Захиргаа, удирдлагын газар:

Захиргаа, удирдлагын газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Хүний нөөцийн бодлого, ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн асуудал, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцан зохион байгуулах;
2. Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах;
3. Компанийн худалдан авалтын үйл ажиллагаа, ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцан зохион байгуулах;
4. Компанийн үйл ажиллагааны тайлан гаргах, нэгтгэх;
5. Компанийн дотоод нэгжийн үйл ажиллагааг уялдуулах, бичиг хэргийн хөтлөлт, удирдлагад туслах ажил үүргийг гүйцэтгэх;

Захиргаа, удирдлагын газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.
- Ерөнхий нягтлан бодогч.
- Нягтлан бодогч: Компанийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн явуулна. Удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангах, тайлан бэлтгэнэ.
- Архив, бичиг хэргийн ажилтан: Компанийн дотоод нэгжийн үйл ажиллагааг уялдуулах, архив, бичиг хэргийн ажилтан, оффис менежерийн үүргийг гүйцэтгэнэ.
- Захиргаа, хүний нөөцийн ажилтан: Ажилтнуудын харилцаа холбоо, хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх замаар байгууллагын хүний нөөцийг сайжруулна.

- Захиргаа, аж ахуй хариуцсан ажилтан: Санхүүгийн гүйлгээг бүртгэх, баримт бүрдүүлэх, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, компанийн худалдан авалтын үйл ажиллагааг хариуцна. Няравын үүргийг гүйцэтгэнэ.
- Жолооч 1: Хариуцсан машин техникээ чадварлаг эзэмшиж, техникийн бэлэн байдлыг бүрэн ханган, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчилнэ.
- Жолооч 2: Хариуцсан машин техникээ чадварлаг эзэмшиж, техникийн бэлэн байдлыг бүрэн ханган, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчилнэ.

Удирдлагын багийн бүрэлдэхүүн, тэдний үүрэг хариуцлага

Гүйцэтгэх захирал:

Компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

- Компанийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах, хянах замаар компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллана.
- Компанийн зорилт, стратеги, бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, ерөнхий удирдлага, чиглэлээр хангана.
- Компанийн төсөв боловсруулах, батлуулах, удирдах, зардлыг хянах, хүний нөөцийн болон санхүүгийн нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангана.
- Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, үнэлэх, зөвлөмж, тайланг судлах, гадна талд байгууллагаа төлөөлнө.

Дэд захирал:

Компанийн тодорхой чиг үүргийг удирдан зохион байгуулна.

- Компанийн зорилт, стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.
- Гүйцэтгэх захирлын эзгүйд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар ханган ажиллана.
- Давхар даатгалын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.
- Сургалт сурталчилгааны ажлыг хариуцна.

Ерөнхий хуульч:

Компанийн ажилтнуудыг хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, шийдвэр албан бичгийн төслийг хянах, компанийг хууль хяналтын байгууллагад төлөөлөх зэргээр компанийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг хангах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Даатгал /давхар/-ын зах зээлийн зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал өгнө.
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах, шинэчлэх, шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавина.
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, зөвтгүүлэх, боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.
- Компанийн бусад этгээдтэй байгуулах гэрээ, хэлцэл, санамж бичгийн төсөл боловсруулах, эрх зүйн үндэслэлийг хянах, зөвтгүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг гүйцэтгэнэ.
- Бүх албан бичгийн төслийг хянах, боловсруулах, зөвтгүүлэх, компанийн хэмжээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хэрэг маргаантай асуудлаар хуулийн байгууллагад төлөөлнө.
- Компанийн нэр бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүртгэх, хянах, хадгалах, АТГ-т тайлагнах, авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулна.

Андеррайтингийн газрын дарга:

Давхар даатгалын эрсдэлийн үнэлгээ хийж, туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг

тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулна.

- Андеррайтингийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, даатгагч нарын давхар даатгуулах эрсдэлийн үнэлгээг /андеррайтинг/ хийнэ.
- Туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- ОУДД-ын байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулна.

Бизнес хөгжил, төслийн газрын дарга:

Зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж турших, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулна.

- Бизнес хөгжил, төслийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж турших ажлыг зохион байгуулна.
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулна.
- Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

Экспортын даатгалын газрын дарга:

Экспортын даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хөгжүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах, ажилтнуудын ур чадварыг сайжруулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулна.

- Экспортын даатгалын газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Шаардлагатай судалгаа, шинжилгээг хийж гүйцэтгэнэ.
- Сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, экспортын даатгалын чиглэлээр мэргэшүүлэх зэрэг ажлыг удирдан зохион байгуулна.
- Гэрээ, хэлэлцээр, батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилтийг хангуулан, хэрэгжилтийн үр дүнг хариуцаж, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга:

Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

- Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Компанийн сангийн хөрөнгийг холбогдох зохицуулалтын хүрээнд удирдана.
- Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг бүрдүүлж, нөхөн төлбөр тооцоолох, олгох ажиллагааг удирдан зохион байгуулна.

Захиргаа, удирдлагын газрын дарга:

Компанийн хүний нөөц, худалдан авалтын асуудлыг хариуцах замаар компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явагдах нөхцөлийг ханган ажиллана.

- Санхүү, удирдлагын газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Хүний нөөцийн бодлого, ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн асуудал, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцна.
- Компанийн ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллана.
- Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хяналт тавих, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, нэгтгэх, тайлагнах ажлыг хариуцна.

Ерөнхий нягтлан бодогч буюу Санхүүгийн тасгийн дарга:

Компанийн нягтлан бодох бүртгэлийн өгөгдөл, мэдээллийг судалж шинжлэн, удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангаж, санхүүгийн тайлан бэлтгэнэ.

- Санхүүгийн тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллана.
- Компанийн жилийн санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулж, батлуулна.
- Компанийн санхүүгийн болон татварын тайланг хариуцан гаргана.
- Компанийн өмчийн хадгалалт хамгаалалтыг хариуцна.

Дотоод хяналтын ажилтан:

Компанийн төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журам, стандарт гэрээг мөрдөж, байгаа байдалд болон хөрөнгө, өр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт зэрэгт дотоод аудит хийнэ.

- Компанийн төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдалд дотоод аудит хийнэ.
- Хөрөнгө, орлого, зарлага, өр, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт зэрэгт дотоод аудитыг явуулна.
- Компанийн онцлогийг тусгасан дотоод аудиттай холбоотой журам, заавар, гарын авлага боловсруулж, батлуулна.

6. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2018 оны санхүүгийн төлөвлөгөөг хийхдээ МИД-ын бүтээгдэхүүнийг 2015-2017 оны борлуулалт, нөхөн төлбөр, давхар даатгал, санхүүгийн үйл ажиллагаа болон зах зээлийн судалгаа, мөн компанийн орлогын 88 хувийг эзлэх хөрөнгө оруулалтын орлого /банкны хадгаламжийн орлого/-д үндэслэн боловсруулсан болно.

МИД-ын бүтээгдэхүүний борлуулалтыг 2018 онд борлуулалтыг 10 хувиар өсгөхөд МИД-ын хураамжийн орлого 2,56 тэрбум төгрөг, даатгалын компаниудын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө 1,15 тэрбум төгрөг болох төлөвтэй байна. Дунд түвшинд гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээг жил бүр хохирлын харьцааны 75 дахь персентайл (percentile) дээр таамагласан нь ойролцоогоор 1,2 тэрбум төгрөгийн хохирол учирч болзошгүй ба үүнийг хамтын эрсдэлийн сан, хамтын эрсдэлийн сангийн нөөц сан, дунд түвшний эрсдэлийн нөөц сангаас тус тус хааж, дунд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сангийн үлдэгдэл 2018 онд 2,6 тэрбум төгрөг болох төлөвтэй байна. Дээд түвшинд гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээг жил бүр хохирлын харьцааны 80 дахь персентайл (percentile) дээр таамагласан нь ойролцоогоор 121,5 сая төгрөгийн хохирол учирч болзошгүй ба үүнийг дээд түвшний эрсдэлийн нөөц сангаас хааж, дээд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сангийн үлдэгдэл 2018 онд 788,6 сая төгрөг болох төлөвтэй байна.

Хөрөнгө оруулалтын орлогыг төлөвлөхдөө “Монгол Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд 1.1. Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2017-2019 онд жилийн 8 хувиас дээшгүй түвшинд байлгана” гэсэн судалгааг үндэслэсэн болно.

2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2018 он
1	Нийт хөрөнгө оруулалтын өгөөж	5,042,286,567.51
1.1	Хадгаламжийн өгөөж	3,927,644,510.66
1.2	Бондын өгөөж	1,114,642,056.85
2	Орлогын албан татвар 10 хувь	392,764,451.07
3	Цэвэр хөрөнгө оруулалтын өгөөж	4,649,522,116.44

Дээрх төлөвлөгөөг тооцохдоо дүрмийн сангийн 15,0 тэрбум, Алдагдлаас хамгаалах сангийн 15,0 тэрбум, Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн 2,5 тэрбум төгрөг, Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн 806,8 сая төгрөг, газар тариалангийн нөөц сангийн 7,9 сая төгрөгийн хөрөнгөд банкны хадгаламж болон Засгийн газрын үнэт цаасанд байршуулахаар тус тус тооцсон болно. Хүүгийн түвшнийг тооцохдоо Төв банкны бодлогын хүү 11 хувь, Засгийн газрын үнэт цаасны хүү 8 хувь, банкны хадгаламж хүү 11 хувиар тооцсон болно.

6.2. ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн орлогын тайланг бэлтгэхдээ МИД-ын давхар даатгалын хураамжийн орлого, хөрөнгө оруулалтын орлогод үндэслэн боловсруулсан болно.

МАЯГТ СЗХ 04131. ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /2018 оны төлөвлөгөө/
/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Мөрийн дугаар	2018 оны 12-р сарын 31
А	Б	В	
1	Даатгалын нийт хураамжийн орлого	1	1,421,478,870.00
1.1	Даатгалын хураамжийн буцаалт	2	
1.2	Давхар даатгалын хураамж	3	748,028,430.00
2	Даатгалын цэвэр хураамжийн орлого (= мөр (1 - 2 - 3))	4	673,450,440.00
2.1	Нийт төлсөн нэхэмжлэл	5	
3	Даатгалын хураамжийн орлогын дүн (= мөр (4 -5))	6	673,450,440.00
4	Даатгалын нөөц сангийн өөрчлөлт	7	
4.1	Алдагдлаас хамгаалах сангийн өөрчлөлт	8	
4.2	Хамтын эрсдэлийн сангийн өөрчлөлт	9	
4.3	Бусад нөөц сангийн өөрчлөлт	10	279,067,230.00
4.4	Даатгалын нөөц сангийн өөрчлөлтийн дүн (= мөр (8+9+10))	11	279,067,230.00
5	Даатгалын хураамжийн бус орлого	12	
5.1	Хөрөнгө оруулалтын орлого	13	5,042,286,567.51
5.2	Давхар даатгалын комиссын орлого	14	7,480,284.30
5.3	Бусад орлого	15	
5.4	Даатгалын хураамжийн бус орлогын дүн (= мөр (13+14+15))	16	5,049,766,851.81
6	Даатгалын орлого дүн (= мөр (6 -11+16))	17	5,444,150,061.81
7	Үйл ажиллагаа (борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	18	
7.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	19	1,200,366,000.00

7.2	Нийгмийн даатгалын шимтгэл	20	149,443,920.00
7.3	Засвар үйлчилгээний зардал	21	33,600,000.00
7.4	Ашиглалтын зардал	22	27,000,000.00
7.5	Түрээсийн зардал	23	153,810,000.00
7.6	Албан томилолтын зардал	24	145,091,000.00
7.7	Тээврийн зардал	25	1,180,000.00
7.8	Түүхий эд материалын зардал	26	7,188,000.00
7.9	Элэгдлийн зардал	27	135,000,000.00
7.10	Зар сурталчилгааны зардал	28	81,621,390.60
7.11	Шуудан, холбооны зардал	29	20,880,000.00
7.12	Шатахууны зардал	30	13,820,000.00
7.13	Найдваргүй авлагын зардал	31	-
7.14	Зээлийн хүүгийн зардал	32	-
7.15	Бусдаар ажил гүйцэтгүүлсэн ажлын зардал	33	30,502,000.00
7.16	Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	34	45,000,000.00
7.17	Интернэшнл СОС ын үйлчилгээний төлбөр	35	-
7.18	Бусад зардал	36	466,465,109.40
7.19	Үйл ажиллагааны зардлын дүн (= мөр (19+.....=36))	37	2,510,967,420.00
8	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал) (= мөр (17 - 37))	38	2,933,182,641.81
9	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	39	
9.1	Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, алдагдал	40	
9.2	Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)	41	
9.3	Ногдол ашгийн орлого	42	
9.4	Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг (алдагдал)	43	
9.5	Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг (алдагдал)	44	
9.6	Хувьцаа, бондын зардлын хорогдуулга	45	
9.7	Хараат болон хамтарсан үйлдвэрээс олсон ашиг	46	
9.8	Бусад	47	
9.9	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн (= мөр (40+41+....47))	48	-
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) (= мөр (38-48))	49	2,933,182,641.81
10.1	Орлогын татварын зардал	50	504,228,656.75
11	Татварын дараах ашиг (алдагдал) (= мөр (49-50))	51	2,428,953,985.06
11.1	Цөөнхөд ногдох хувь	52	
12	Ердийн ажиллагааны ашиг (алдагдал) (= мөр (49-50))	53	2,428,953,985.06
12.1	Онцгой шинжтэй зүйлс-цэвэр	54	
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) (= мөр (53-54))	55	2,428,953,985.06
13.1	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	56	

6.3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

МАЯГТ СЗХ04130. ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /2018 оны төлөвлөгөө/ /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Мөрийн дугаар	2018 оны 12-р сарын 31
A	Б	В	
1	ХӨРӨНГӨ	1	
1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2	
1.1.1	Бэлэн мөнгө	3	-
1.1.2	Харилцах	4	300,000,000.00
1.1.3	Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	5	
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	6	115,794,797.02
1.1.5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	7	415,794,797.02
1.2	Даатгалын авлага	8	
1.2.1	Даатгалын хураамжийн авлага /цэвэр дүнгээр/	9	7,512,064.72
1.2.2	Давхар даатгалаас авах авлага /цэвэр дүнгээр/	10	
1.2.3	Даатгалын авлагын дүн	11	7,512,064.72
1.3	Бусад санхүүгийн хөрөнгө	12	
1.3.1	Бусад авлага /цэвэр дүнгээр/	13	
1.3.2	Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	14	-
1.4	Бусад санхүүгийн бус хөрөнгө	15	
1.4.1	НДШ авлага, бусад татварын авлага	16	
1.4.2	ААНОАТатварын авлага	17	
1.4.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	18	
1.4.4	Бараа материал	19	
1.4.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	20	-
1.4.6	Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/	21	
1.4.7	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	22	-
1.5	Хөрөнгө оруулалт	23	
1.5.1	Хадгаламж, хадгаламжийн сертификат	24	44,425,116,386.58
1.5.2	Үнэт цаас /цэвэр/	25	
1.5.3	Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	26	
1.5.4	Үнэт металл, Дериватив	27	
1.5.5	Хөрөнгө оруулалтын дүн	28	44,425,116,386.58
1.6	Даатгалын хөрөнгө	29	
1.6.1	ДД-ын хойшлогдсон хураамж	30	-
1.6.2	Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг	31	
1.6.3	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	32	
1.6.4	Даатгалын хөрөнгийн дүн	33	-
1.7	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	34	319,858,921.40

1.8	Биет бус хөрөнгө /Цэвэр/	35	435,256,136.88
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	36	
1.10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	37	45,603,538,306.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	38	
2.1	ӨР ТӨЛБӨР	39	
2.1.1	Даатгалын өглөг	40	
2.1.1.1	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	41	
2.1.1.2	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	42	
2.1.1.3	ДД өгөх өглөг	43	-
2.1.1.4	Даатгалын өглөгийн дүн	44	-
2.1.2	Бусад санхүүгийн өр төлбөр	45	
2.1.2.1	Зээлийн өглөг, хүү	46	
2.1.2.2	Өрийн бичиг, хүү	47	
2.1.2.3	Санхүүгийн түрээсийн өр төлбөр	48	
2.1.2.4	Ногдол ашгийн өглөг	49	
2.1.2.5	Деривативын өр төлбөр	50	
2.1.2.6	Бусад өр төлбөр	51	
2.1.2.7	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	52	
2.1.3	Бусад санхүүгийн бус өр төлбөр	53	
2.1.3.1	Цалингийн өглөг	54	
2.1.3.2	НДШ-ийн өглөг	55	
2.1.3.3	ААНОАТатварын өглөг	56	504,228,656.75
2.1.3.4	Хойшлогдсон татварын өглөг	57	
2.1.3.5	Урьдчилж орсон орлого	58	-
2.1.3.6	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр	59	
2.1.3.7	Хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсийн өр төлбөр	60	
2.1.3.8	Мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион	61	
2.1.3.9	Тэтгэврийн сангийн өр төлбөр	62	
2.1.3.10	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	63	
2.1.3.11	Бусад санхүүгийн бус өр төлбөр	64	69,320,380.79
2.1.3.12	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн	65	573,549,037.54
2.1.4	Хоёрдогч өглөг	66	
2.1.5	Давуу эрхийн хувьцаа (хөрвөхгүй)	67	
2.1.6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	68	200,000,000.00
2.1.7	Нөөц сан	69	
2.1.7.1	Алдагдлаас хамгаалах сан	70	-
2.1.7.2	Хамтын эрсдэлийн сан	71	-
2.1.7.3	Эрсдэлээс хамгаалах сан	72	-
2.1.7.4	Бусад нөөц сан	73	
2.1.7.6	Нөөц сангийн дүн	74	-
2.1.8	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	75	773,549,037.54
2.2	ЭЗДИЙН ӨМЧ	76	
2.2.1	Эзэмшигчдийн өмч	77	15,000,000,000.00
2.2.2	Халаасны хувьцаа	78	

2.2.3	Нэмж төлөгдсөн капитал	79	
2.2.4	Тогтвортой байдлын нөөц сан	80	19,731,340,821.93
2.2.5	Хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	81	
2.2.6	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	82	
2.2.7	Эздийн өмчийн бусад хэсэг	83	
2.2.8	Хуримтлагдсан ашиг, алдагдал	84	10,098,648,447.13
2.2.9	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	85	44,829,989,269.06
2.3	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	86	45,603,538,306.60

7. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

7.1. УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ

Монгол Улсын эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 2011-2012 онд нийлбэр дүнгээр 9.0 тэрбум ам.долларт хүрч, нэг жилд ногдох ГШХО-ын дундаж хэмжээ нь мөн хугацаанд ДНБ-ий 40 гаруй хувийг эзэлж байсан бол 2016 онд ГШХО ердөө 276 сая ам.доллар болж ДНБ-ий 2 хувьтай тэнцэх түвшин рүү огцом буурчээ. Хятадын эдийн засгийн өсөлт үргэлжлэн удааширч, уул уурхайн түүхий эдийн гадаад эрэлт бууран, хөрөнгийн урсгал хөгжингүй орнуудыг чиглэж, Хятад улс болон хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад хийх хөрөнгө оруулалтын хэмжээ буурах сөрөг хандлага 2017 онд ч үргэлжиллээ. АНУ-ын Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын нөлөөгөөр ам.долларын ханш дэлхийн бусад валютын эсрэг чангарсан болон манай улс руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт, ашигт малтмалын түүхийн эдийн үнийн уналт зэрэг хүчин зүйл нь үндэсний валютын ханш болон гадаад валютын нөөцөд нэмэлт ачаалал, сөрөг нөлөөллүүд бий болгосоор байна. Хэдийгээр дотоодын эдийн засаг болон санхүүгийн салбарын нөхцөл байдал хүндэрсэн ч 2017 оны сүүлийн хагаст дэлхийн зах зээлд Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр, цайр зэрэг ашигт малтмалын үнэ өсөх хандлага ирэх жилүүдэд ажиглагдаж байна.

Улс төр, эдийн засгийн орчин муудах, түүний тодорхойгүй байдал, институцийн чадавх зэрэг нь бизнес, санхүүгийн байгууллагуудад хүчтэй нөлөөлдөг төдийгүй компанийн бүтээгдэхүүн хэрэглэгч буюу малчдын амьжиргааны түвшинд сөрөг үр дагавар үзүүлж, бүтээгдэхүүн борлуулах үйл явцад эрсдэл бий болдог. Хөдөө аж ахуйн салбар нь монголчуудын уламжлалт салбар бөгөөд ДНБ-ийн 20 орчим хувийг үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамж, үндэсний үйлдвэрийн түүхий эдийн гол тулгуур болж байгаа тул хөгжлийн түвшнийг тодорхойлох нэг үндэс суурь юм. Түүнчлэн манай улсад ажиллагсдын 35 орчим хувь нь тус салбарт ажиллаж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааны гол эх үүсвэрээ болгож байгаа нь мал аж ахуй, газар тариалангийн салбараас манай орны эдийн засаг ихээхэн хамааралтайг харуулж байна. Тухайн салбар өсөж хөгжихийн хирээр хөдөө аж ахуйн давхар даатгалын эрэлт нийлүүлэлт ихсэж, өргөжин тэлэх чухал ач холбогдолтой. Тиймээс “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн баримтлах зорилтын хүрээнд хөдөө аж ахуйн салбарын хөгжил, цаашид эдийн засгийн салбарт авчрах өгөөжийг судлан дүгнэлт гаргаж, “Үр ашигтай эрсдэлийн удирдлага”-ыг цогцоор нь хэрэгжүүлэх нь нэн тэргүүний асуудал юм. Компанийн эрсдэлийн бодлогын зорилго нь даатгуулсан даатгуулагч, хамтран ажиллагч байгууллагуудын эрсдэлийг зөв зохистой удирдах, компанийн төлбөрийн чадвар, нөөцийн санг зохистой хэмжээнд тооцоолж, өөрийн байр суурийг нэмэгдүүлж, даатгалын эрсдэлийг боломжит доод хэмжээнд барьж, үр ашигтай хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэж байна.

Төр засгийн шийдвэрээс үүсэх эрсдэл

Сүүлийн жилүүдэд засаглалын сул талууд өмнөх үеэсээ илүү тод харагдаж, авлига өндөртэй болж, дотоодын улс төрийн тогтворгүй байдал ихсэж, төрөөс батлагдан гарч буй хууль тогтоомжууд хэрэгжих боломжгүй эсвэл богино хугацаанд өөрчлөгдөж, аливаа эхлүүлсэн ажлууд үр дүнгээ өгөлгүй зогсож байгаа нь ихээхэн эрсдэл дагуулж байна. Түүнчлэн малчдын зүгээс хүлээлт үүсгэдэг муу талтай. Иймд, өнөөгийн нийгэм улс төрийн байдлыг ажиглан судалж, компанийн үйл ажиллагаатай холбогдуулан эдийн засаг болон хөдөө аж ахуйн салбартай хамааралтай хууль эрх зүйн шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, таамаглал боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

УИХ-ын хууль тогтоомж:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр,
- Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал,
- Монгол Улсын 2017 оны улсын төсвийн тухай хууль,
- “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”,
- Төрөөс малчдын талаар баримтлах бодлого,
- Тариалангийн тухай хууль,
- Органик хүнсний тухай хууль, зэрэг хууль тогтоомжуудыг судлан үзэж, хөдөө аж ахуйн салбарын талаарх зүйл заалтуудад шинжилгээ хийж, хэрэгжилт болон хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах, компанийн зорилтыг биелүүлэхэд хууль хэрэгжүүлэгч бодлогын газруудтай хамтарч ажиллах талаар судлах

Мөн УИХ-д 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа “Мал, амьтны эрүүл мэндийн тухай”, “Малын генетик нөөцийн тухай” зэрэг хуулийн төслүүдийг эгүүлэн татаж, шинэ бүрэн эрхийн хугацаанд дахин өргөн мэдүүлж, батлуулахаар болсон байна. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн Малын генетик нөөцийн тухай, Бэлчээр хамгаалах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийг тус тус боловсруулан батлуулж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхээр зорьж байна. Цаашид:

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх, “Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулах
- Малжуулах хөтөлбөр
- Малчдыг орон сууцжуулах хөтөлбөр
- Бэлчээрийг мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан, мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг нэмэгдүүлж, малчин өрхийн орлогыг дээшлүүлэх
- Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ. Бүртгүүлсэн мал даатгалд хамрагдсан талаар мэдээллийг давхар бүртгэлжүүлж цахимжуулах
- Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангана.

Засгийн газрын тогтоол шийдвэр:

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх тухай ЗГ-ын 113-р тогтоол, 2016-02-22

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай ЗГ-ын 114 -р тогтоол, 2016-02-22
- Малчдыг дэмжих зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 90-р тогтоол, 2016-02-04 /Хөтөлбөрийн хэрэгжилтийг ЗГ-ын 2016-8-10-ны өдрийн 33-р тогтоолоор зогсоосон/
- Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 322-р тогтоол, 2016-06-13

ХХААХҮЯ-ны дэргэд хэрэгжиж буй ХАА-н төсөл хөтөлбөрүүдийг судалж, хамтарч ажиллах талаар санал дэвшүүлэх, малчид, тариаланчдыг даатгалд хамруулах үйл явцыг тэдгээр төсөл, хөтөлбөр болон адил төстэй байгууллагуудын тусламжтайгаар буюу борлуулалтын шинэ суваг гаргахад анхаарч судлах шаардлагатай байна.

Санхүүгийн эрсдэл

УИХ-ын эдийн засгийн байнгын хорооны хуралдаан 2017 оны 11-р сарын 29-ны өдөр болж, Төв банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлсэн. Хэлэлцүүлгээр Монгол банкны дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн инфляц тогтвортой урт, дунд хугацаанд хадгалагдаж чадах бол хадгаламжийн хүүд дээд хязгаар тогтоож болно гэсэн байр суурь илэрхийлэв. Энэ хуулийн төсөл батлагдаж, хадгаламжийн хүүг төрөөс хязгаарласан тохиолдолд манай компанийн хувьд 2018-2020 онд тооцоолсон хадгаламжийн хүү буурах хамгийн том эрсдэл болж байна. Ийм тохиолдолд бусад хөрөнгө оруулалтын сувгуудаас хамгийн өндөр өгөөж, хамгийн бага эрсдэл үүсэхээр сонгон байршуулж болно.

Эрсдэлийг бууруулахын тулд дараах аргуудыг ашиглаж болно.

- Эрсдэлийг даатгах
- Эрсдэлээс зайлсхийх
- Эрсдэлийг багасгах /диверсификаци/
- Эрсдэлд дасан зохицох
- Эрсдэлийг хойшлуулах
- Сөрөг хамааралтай хөрөнгүүд дээр багц бүрдүүлэх зэрэг болно.

Малчдаас үүсэх эрсдэл

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ын эрсдэл нэн тэргүүнд малчин иргэдээс хамааралтай байдаг тул гадаад, дотоод орчны эрсдэлийг тодорхойлохоос өмнө малчин өрхүүдээс үүсэж болох эрсдэлийг шинжлэх нь зүйтэй.

Малчин өрхийн амьжиргааны түвшин, орлогоос хамааран малчид малаа даатгуулах боломжгүй байдаг. Байгаль цаг уурын болон зах зээлийн орчны таатай бус өөрчлөлтийн улмаас малчдын амьжиргааны түвшин тогтвортой бус байнга өөрчлөгдөж байна. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх үр ашигтай суваг бүрдээгүй нь малчдын амьжиргааг бүрдүүлэхэд бодит саад бэрхшээл учруулж байна. Улс орон бүр эдийн засгийн өсөлт, хүний хөгжил, байгалийн нөөц, баялгийн ашиглалт гурвын хоорондын оновчтой шүтэлцээ уялдааг хангахгүйгээр ямар ч салбар ирээдүйд тогтвортой хөгжих боломжгүй болохыг хүлээн зөвшөөрөөд байна. Мал аж ахуйн хөгжил нь хоорондоо нягт шүтэлцээ бүхий малчин-мал-бэлчээр-капитал-менежмент гэсэн үндсэн 5 хүчин зүйлээр тодорхойлогдоно. Мал ахуйн салбар, тэнд ажиллагсдын хөдөлмөр, нийгмийн асуудлыг сайжруулах бодлогыг малчин өрх бүрт хүргэхийн тулд малчин өрхүүдийн аж ахуйн эдийн засгийн ашиг тус, зах зээлтэй холбогдож буй байдлыг судалж үнэлэлт өгөх, сайжруулах боломж арга замыг тодорхойлох шаардлагатай байна.

Малчин өрхийн амьжиргааны түвшин нь дараах нөхцөлүүдээс хамааран харилцан адилгүй байна. Үүнд:

- Малчин өрхүүд нь өргөн уудам нутагт тархан суурьшдаг бөгөөд цаг уурын болон бэлчээрийн мал маллах янз бүрийн нөхцөлд байдаг.
- Төв суурин газраас алслагдах зайнаас хамааран өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ харилцан адилгүй

борлуулалттай. Орлогын нөгөө тал болох малчин өрхийн зарлагыг судлан үзвэл хүнсний хэрэглээ болон ахуйн хэрэглээний бараа, эрүүл мэнд, боловсрол соёлын зардлууд болон иргэний үүргийн биелэлт бүхий зарцуулалтыг хийдэг.

- Малын тоо, төрөл нь малчин өрх бүрд харилцан адилгүй байгаагаас хамааран орлогын хэмжээ өөр өөр байдаг. Малын тоо нь тогтвортой орлоготой байлгах амьжиргааны эх үүсвэр ба байгаль цаг уурын нөлөөнөөс ихээхэн хамаардаг эрсдэлтэй.
- Малчин өрхийн орлогын нэг чухал эх үүсвэр бол малаа борлуулсны орлого, мөн малаас авч буй ашиг шим болох бүтээгдэхүүн борлуулалтын /мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, түүхий эд.. г.м/ орлого. Үүнээс гадна бусдын мал маллаж нэмэлт орлого олох, гарын ур дүйтэй малчин иргэд гэр ахуйн болон малын тоног хэрэгсэл хийж худалдаалах, байгалийн хишиг олборлон борлуулах зэрэг орлогын бусад төрлүүд байх авч ихэнх малчин өрхүүд мал аж ахуйгаа дагнан амьжиргаагаа залгуулж байна.

Малчдын мэдлэг боловсрол

Мал аж ахуйн салбарын бүтээмжид нөлөөлж буй хүчин зүйлсийг мэдлэг, боловсрол, туршлага, технологи, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр тодорхойлж болно. Малчид мал аж ахуйн арвин туршлагатай боловч технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын тогтолцоо, хамтран ажиллах арга хэлбэрээ олоогүй, мэдээллээс хоцрогдмол, бүтээгдэхүүнээ зах зээлд үр ашигтай худалдахад сайтар суралцаагүй зэрэг дутагдал ажиглагдаж байна. Хөгжил дэвшлийн шийдвэрлэх хүчин зүйл нь хүн өөрөө юм. Тиймээс мал аж ахуйн салбарын хөгжлийг малчин хүнд хөрөнгө оруулж хөгжүүлэхгүйгээр дэвшил гарахгүй. Иймээс үндэсний хэмжээнд малчдын мэдлэг боловсролд анхаарч ажиллах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах, мэдээллээр бүрэн хангах нөхцөл бололцоог бүрдүүлэхийн сацуу цаг тухайд нь малчдад хүргэхэд анхаарах шаардлагатай. Иймд, байгууллагын зүгээс үйл ажиллагаа ижил төстэй төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран малчин өрх бүрд тэдний амьдрал ахуй, хөдөө аж ахуйн салбартай холбоотой төр засгийн шийдвэрүүдийг танилцуулахын сацуу хөдөө аж ахуйн даатгалын талаар мэдлэг мэдээлэл хүргэж, давуу талуудыг таниулах төлөвлөгөөтэй ажиллана. Засгийн газрын зүгээс мал аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр хэрэгжүүлэхээр зорьж байна. Тогтвортой, хариуцлагатай, эрх зүйт төрийг төлөвшүүлэхийн тулд хөдөөгийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах, малчдыг мэдээллээр хангах хөтөлбөр хэрэгжүүлж, сум, багийнхаа үйл ажиллагаанд орон зайн тэгш бус байдлаас үл хамааран жигд оролцох боломжоор хангахаар бодлого боловсруулсан байгааг компанийн зүгээс оролцоотой төлөвлөгөөнд тусгах ажиллахад тодорхой үүрэг оролцоотой ажиллах хэрэгтэй байна. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь одоогоор МИД-ын бүтээгдэхүүнийг давхар даатгалд хамруулж байгаа тул санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны орлого хангалттай бус байх эрсдэлтэй юм. Мөн түүнчлэн малын даатгал нь сайн дурын даатгал бөгөөд малчдын хамрагдалтаас давхар даатгалын компанийн орлого шууд хамааралтай байгаа. МИД-ын бүтээгдэхүүн нь одоогоор төлөөлөгчийн сувгаар борлуулагдаж байгаа бөгөөд зардал өндөртэй тул борлуулалтын суваг нэмэгдүүлсэн байх шаардлагатай юм.

7.2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЭРСДЭЛ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь “Даатгалын тухай хууль”, “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль” болон бусад холбогдох хууль, СЗХ-ноос баталсан “Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлт, байршуулалт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам”, “Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”, “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам” болон бусад холбогдох дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын тухай хууль нь Монгол улсад даатгалын үйл ажиллагаа явуулж буй байгууллагын даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг ерөнхий хууль юм.

ДҮГНЭЛТ

МИД-ын бүтээгдэхүүний борлуулалтыг 2018 онд борлуулалтыг 10 хувиар өсгөхөд МИД-ын хураамжийн орлого 2,56 тэрбум төгрөг, даатгалын компаниудын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө 1,15 тэрбум төгрөг болох төлөвтэй байна. Дунд түвшинд гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээг жил бүр хохирлын харьцааны 75 дахь персентайл (percentile) дээр таамагласан нь ойролцоогоор 1,2 тэрбум төгрөгийн хохирол учирч болзошгүй ба үүнийг хамтын эрсдэлийн сан, хамтын эрсдэлийн сангийн нөөц сан, дунд түвшний эрсдэлийн нөөц сангаас тус тус хааж, дунд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сангийн үлдэгдэл 2018 онд 2,6 тэрбум төгрөг болох төлөвтэй байна. Дээд түвшинд гарч болзошгүй нөхөн төлбөрийн хэмжээг жил бүр хохирлын харьцааны 80 дахь персентайл (percentile) дээр таамагласан нь ойролцоогоор 121,5 сая төгрөгийн хохирол учирч болзошгүй ба үүнийг дээд түвшний эрсдэлийн нөөц сангаас хааж, дээд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сангийн үлдэгдэл 2018 онд 788,6 сая төгрөг болох төлөвтэй байна.

2018 онд үрийн тариалангийн даатгалын 1125 га талбайг даатгалд хамруулж, даатгуулагчаас авах даатгалын нийт хураамжийн орлогыг 48,6 сая төгрөг байхаар төлөвлөж байна. Үүнээс Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн цэвэр хураамж 12,3 сая төгрөг болохоор байна.

Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2018 оны санхүүгийн төлөвлөгөөг хийхдээ МИД болон газар тариалангийн бүтээгдэхүүний борлуулалт, нөхөн төлбөр, давхар даатгал, санхүүгийн үйл ажиллагаа болон зах зээлийн судалгаа, мөн компанийн орлогын 88 хувийг эзлэх хөрөнгө оруулалтын орлогод үндэслэн боловсруулсан болно.

МИД-ын хураамжийн орлогыг өнгөрсөн оныхоос 10 хувиар, газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний хураамжийн орлогыг 5 хувиар өсгөж нийт 2,6 тэрбум төгрөгийн хураамжийн орлого, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д төвлөрөх нийт 1,4 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Хөрөнгө оруулалтын орлогоор нийт 40,5 тэрбум төгрөгийг банкны хадгаламж болон Засгийн газрын үнэт цаас худалдан авч нийт 2,8 тэрбум төгрөгийг хуримтлуулахаар байна.

Үйл ажиллагааны зардлыг өнгөрсөн оныхоос 32 хувиар өсгөж 2,5 тэрбум төгрөг байхаар төлөвлөж байна.

ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд одоогоор их хэмжээний эрсдэл хүлээх чадвар буюу нөөц хөрөнгө харьцангуй багатай тул ойрын хэдэн жилдээ давхар даатгалд хамруулсан хариуцлагын ихэнх хэсгийн ОУ-ын давхар даатгагч нарт шилжүүлэн улмаар дотоодын нөөц хөрөнгийн хамгаалах, өсгөх төлөвлөгөөтэй байна.

Малын индексжүүлсэн даатгал

МИД-ын тухай хуульд зааснаар ҮСХ-ны хагас жилийн мал тооллогын дүнд үндэслэн оролцогч даатгагчдын хурал болон давхар даатгалын компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гарсан үед давхар даатгалын компанийн гүйцэтгэх захирал нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг зохион байгуулна.

“Хөдөө Аж ахуйн Давхар Даатгал” ХК оролцогч даатгагчдын дансанд нөхөн төлбөр авах малчдын мэдээлэл болон нөхөн төлбөрт шаардагдах мөнгийг шилжүүлнэ. Даатгагч нөхөн төлбөрийг хүлээн авч даатгуулагчдад олгох нөхөн төлбөрийг даатгалын тохиолдол гарсан сум бүрд байгаа гэрээт арилжааны банкны салбарт шилжүүлэх юм. Компанийн зүгээс хэрэв 2018 оны эхний хагас жилд малын хохирол Хамтын эрсдэлийн хуримтлалаас хэтрэхгүй нөхөн төлбөр гарсан тохиолдолд дараах хэмжээгээр 2018 оны эрсдэл даах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөөд байна.

Борлуулалтын төлөвлөгөөний дагуу нийт даатгалын хураамж 2,562,026,459.08 төгрөг, нийт сонгосон үнэлгээ 60,790,202,597.49 төгрөг байх ба үүнээс тооцоолол хийвэл:

Эрсдэлийн дунд түвшинд: Хамтын эрсдэлийн санд нийт хураамжийн 45 хувь буюу 1,152,911,906.59 төгрөгийг, дунд түвшний нөөцөд 128,101,322.95 төгрөгийг нэмж хуримтлуулах ба ОУ-ын давхар даатгалтай хамт хариуцах нийт эрсдэл нь 7,202,621,469.71 төгрөг байна.

Эрсдэлийн дээд түвшинд: Дээд түвшний нөөцөд 182,190,607.79 төгрөг хуримтлуулж, дээд түвшний олон улсын давхар даатгалтай хамт хариуцах нийт эрсдэл нь 2,671,294,038.09 төгрөг байна.

Нийтдээ дунд болон дээд түвшинд 9,873,915,507.80 төгрөгийн эрсдэлийг даах чадвартай байна.

Нийт даатгалын хураамж	2,562,026,459.08
Нийт сонгосон үнэлгээ	60,730,202,597.49

Эрсдэлийн дунд түвшин	2018	Хуримтлал	Нийт
Хамтын эрсдэлийн сан	1,152,911,906.59	114,027,694.59	1,266,939,601.18
Дунд түвшний нөөц	128,101,322.95	2,476,946,148.78	2,605,047,471.73
ОУ Давхар Даатгал-дунд	3,330,634,396.80		3,330,634,396.80
			7,202,621,469.71

Эрсдэлийн дээд түвшин			
Дээд түвшний нөөц	182,190,607.79	697,562,453.67	879,753,061.46
ОУ Давхар даатгал-Дээд	1,791,540,976.63		1,791,540,976.63
			2,671,294,038.09

Нийт эрсдэл даах чадвар	9,873,915,507.80
--------------------------------	-------------------------

Газар тариалангийн даатгал

Газар тариалангийн даатгалын хувьд 2018 онд СКОР олон улсын давхар даатгалын компанитай хамтран индекст суурилсан бүтээгдэхүүнийг туршихаар төлөвлөж байгаа бөгөөд эрсдэлийн 80 хувийг олон улсын давхар даатгагчид шилжүүлэн үлдсэн 20 хувийг дотоодын даатгагчтай хамтран хариуцах болно.

Хөрөнгийн даатгал

Малын болон газар тариалангийн даатгалын хувьд эрсдэл өндөртэй даатгалын бүтээгдэхүүн тул компанийн зүгээс өөрийн хүлээх эрсдэлээ тархаах зорилгоор бусад хөрөнгийн давхар даатгалын зах зээлд орж ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа юм. Иймд компанийн зүгээс 2018 оны хувьд эрчимжсэн ферм болон бусад үл хөдлөх хөрөнгийн давхар даатгалыг хийхээр төлөвлөж байна.

Давхар Даатгалын нийт хуваарилалт

Хураамжийн хуваарилалт:

	Нийт даатгалын хураамж	ХААДД ХК- ийн нийт хураамж	ОУ Давхар даатгал	ХААДД ХК-ийн үлдэгдэл хураамж
Малын индексжүүлсэн даатгал	2,562,026,459.08	819,848,466.91	384,303,968.86	435,544,498.04
Газар тариалангийн бүтээгдэхүүн	48,644,084.24	47,184,761.71	38,915,267.39	12,306,953.31
Хөрөнгийн даатгал	76,000,000.00	72,200,000.00	60,800,000.00	11,400,000.00
<i>Эрчимжсэн мал аж ахуй</i>	<i>36,000,000.00</i>	<i>25,200,000.00</i>	<i>20,160,000.00</i>	<i>5,040,000.00</i>
<i>Бусад</i>	<i>40,000,000.00</i>	<i>28,000,000.00</i>	<i>14,000,000.00</i>	<i>14,000,000.00</i>
Нийт	2,686,670,543.32	939,233,228.62	484,019,236.25	459,251,451.35